



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/176

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Дэлгэрхаан, Хэрлэн сумдад халдвар бүртгэгдэж, аймгийн Онцгой комиссын шийдвэрээр "Улаан түвшин"-д шилжүүлсэн тул Засгийн газрын 45 дугаар тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар /ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын хэрэгжилтийг хангах, иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох зорилгоор "Чингис хотыг бүсчлэн хаах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж, хяналтын 11 постод энэ оны 04 дүгээр сарын 10-ны 06.00 цагаас 04 дүгээр сарын 25-ны 00.00 цаг хүртэл 15 хоногийн хугацаанд ажиллах 22 алба хаагчийн хоол, автомашины шатах тослох материалын зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Мөн Бор-Өндөр сумын "Төмөрт овоо", Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан тосгонд хяналтын пост байгуулж, үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоол, тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг Бор-Өндөр, Дэлгэрхаан сумдын Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулсугай.

3. Урьдчилан сэргийлэх, халдварын тархалтын түвшинг тогтооход шаардагдах 11.427.500 /арван нэгэн сая дөрвөн зуун хсрин долоон мянга таван зуу/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах саггаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011634

04 Аймгийн Засаг даргын 2023 оны  
... дугаар сарын ... өдрийн АИТГ  
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ				Дүн
	Шатахууны зардал	Шуурхай штаб	Хоолны зардал	Тусгаарлах байрны түлш	
Цагдаагийн газар	2.557.500		6.600.000	150.000	9.307.500
Онцгой байдлын газар	620.000	1.500.000			2.120.000
<b>Дүн</b>	<b>3.177.500</b>	<b>1.500.000</b>	<b>6.600.000</b>	<b>150.000</b>	<b>11.427.500</b>